



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/16

Мандалговь

Аймгийн онцгой комиссын бүрэлдэхүүн,
ажиллах журмыг батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2,23.3 дахь зүйл, Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:
Нэг. Аймгийн онцгой комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

- | | |
|----------------------|---|
| Дарга | - Аймгийн Засаг дарга |
| Орлогч дарга | - Аймгийн Засаг даргын орлогч |
| | - Онцгой байдлын газрын дарга |
| Гишүүд: | - Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга |
| | - Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга |
| | - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| | - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | - Хууль зүйн хэлтсийн дарга |
| | - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| | - Эрүүл мэндийн газрын дарга |
| | - Мэргэжлийн хяналтын газрын дарга |
| | - Цэргийн штабын дарга |
| | - Цагдаагийн газрын дарга |
| | - Тагнуулын хэлтсийн дарга |
| | - Ус, цаг уур орчны шинжилгээний газрын дарга |
| | - Улаан загалмайн хорооны дарга /тохиролцсоноор/ |
| | - "Мэдээлэл, холбоо сүлжээ" компанийн Дундговийн салбарын захирал |
| | - Багануур зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ |
| | - ТӨХК-ны Дундговь аймаг дахь салбарын дарга |
| | - Дундговь ус ОНӨУ газрын дарга |
| | - Тээвэр, авто замын газрын дарга |
| | - Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын дарга |
| | - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| | - Нутаг дэвсгэрт нь онцгой байдал үүссэн сумын Засаг дарга |
| Нарийн бичгийн дарга | -Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга |

Хоёр. Аймаг (сум)-ийн онцгой комиссын ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 04 сарын 16-ны өдрийн А/144 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



0200049



АЙМАГ (СУМ)-ИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ.

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аймаг (сум)-ийн онцгой комисс (цаашид "комисс" гэх)- нь өөрийн харьяа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн аюулаас хүн ам, мал, амьтан хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн төрийн болон аж ахуйн нэгж албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавихдаа энэхүү журмыг дагаж мөрдөнө.
2. Комисс нь гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.
3. Аймгийн онцгой комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга, сумын онцгой комиссын бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга тус тус батална.
4. Комиссын дарга нь аймгийн Засаг дарга, орлогч дарга нь аймгийн орлогч дарга, онцгой байдлын газрын дарга нар байна.
5. Комиссын хурал нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тэмдэглэл гаргана.
6. Комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар албан даалгавар гаргана.
7. Комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.
8. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг аймагт онцгой байдлын газар, суманд Засаг даргын Тамгын газар эрхэлнэ.

Хоёр. Комиссын эрх, үүрэг

9. Комиссын үүрэг

- 9.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний биелэлтийг хангуулах ажлыг орон нутгийн төрийн болон аж ахуйн нэгж, төрийн бус, олон нийтийн байгууллагаар гүйцэтгүүлэх Монгол Улсын Шадар Сайд, Улсын онцгой комиссоос энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх;
- 9.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 9.3. Үүссэн нөхцөл байдлаас хамаарч шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын холбогдох албан тушаалтныг онцгой комиссын

- хуралд дуудаж оролцуулах ба мэргэжлийн байгууллагаас өгсөн үнэлэлт, дүгнэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэж шийдвэр гаргах;
- 9.4. Гамшгийн голомтод Засгийн газар, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас олгосон бараа, материал, тусламж хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих;
- 9.5. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн, хүч техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг орон нутгийн төрийн байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах;
- 9.6. Гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хүч хүрэлцэхгүй болсон үед Улсын онцгой комисст албан ёсны хүсэлт тавих;
- 9.7. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх;
- 9.8. Гамшиг тохиолдсон үед хохирлыг үнэлэх ажлын хэсгийг зохих мэргэжлийн бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж, дүгнэлт гаргуулах;

10. Комисс дараах эрхтэй байна.

- 10.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 10.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийн хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах;
- 10.3. Холбогдох байгууллага албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээлэл, судалгаа гаргуулан авах, илтгэл мэдээллийг хурлаараа хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах, хяналт тавих;
- 10.4. Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авах;
- 10.5. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийн холбогдох журмын дагуу ашиглах;

Гурав. Сумын онцгой комисс

11. Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн сумын онцгой комисс (цаашид комисс гэх)-ыг байгуулна.
- 11.1. Комиссын дарга нь сумын Засаг дарга, орлогч нь Тамгын газрын дарга байна.

- 11.2 Комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй.
- 11.3 Сумын онцгой комисс нь үүссэн нөхцөл байдал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хэлэлцэн, шийдвэрийг хүсэлтийн хамт аймгийн онцгой комисст яаралтай ирүүлнэ.
- 11.4 Сумын нутаг дэвсгэрт тохиолдсон гамшгийн улмаас учирсан хохирлыг эхний ээлжинд гамшгаас хамгаалах нөөц сангийн хөрөнгөөс зарцуулах, хэрэв дээрх хөрөнгө дууссан тохиолдолд аймгийн онцгой комисст сумын Засаг даргын гамшгаас хамгаалах нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын тайланг бичгээр ирүүлсэний дараа аймгийн Засаг даргын нөөц сангаас нэмэлт санхүүжилт гаргуулах хүсэлтээ ирүүлэх
- 11.5 Комисс нь энэхүү журамд заасан үүргийг биелүүлж, эрхийг эдэлнэ.

Дөрөв. Комиссын зардал

12. Аймгийн болон сумын онцгой комисс нь жилийн ажлын төлөвлөгөөнийхөө дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулах зардлыг жил, улирал, сарын хуваарьтайгаар төлөвлөн Засаг даргаар батлуулан цаг тухай үед нь зохих журмын дагуу шийдвэр гаргуулан зарцуулна.

Тав. Бусад зүйл

13. Сумын онцгой комисс нь тухайн жилд гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах чиглэлээр зохион байгуулсан ажлын тайланг жил бүрийн 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн онцгой комисст, аймгийн онцгой комисс нь хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 12 дугаар сард Улсын онцгой комисст хүргүүлнэ.
14. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ноогдуулах саналаа эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИСС